



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/656.

Ховд

Захиргааны статистикийн мэдээг  
боловсронгуй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Статистикийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг тодорхойлох түүнд дүн шинжилгээ хийх боломжийг сайжруулах, статистикийн мэдээллийг нэмэгдүүлэх зорилгоор захиргааны статистикийн мэдээллийг боловсронгуй болгон хамрах хүрээг өргөжүүлж 2020 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Захиргааны статистик мэдээллийг гаргах маягт, хамрагдах аж ахуйн нэгж байгууллагыг хавсралтаар баталсугай.

3. Мэдээ тайланг графикт хугацаанд нь аймгийн Статистикийн хэлтэст ирүүлж байхыг холбогдох газар, хэлтсийн дарга, захирал, эрхлэгч нарт, биелэлтийг хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс /Д.Даваасамбуу/-т үүрэг болгосугай.


4. Уг захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2014 оны 223 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
11 дүгээр сарын 03-ны өдрийн  
А/656 дугаар захирамжийн хавсралт



Захиргааны Статистик мэдээллийг гаргах аж ахуйн  
нэгж байгууллагын нэрс

д/д	Байгууллагын нэр
1	Улсын бүртгэлийн хэлтэс
2	Эрүүл мэндийн газар
3	Боловсрол, соёл урлагийн газар
4	Нийгмийн даатгалын хэлтэс
5	Эрүүл мэндийн даатгал
6	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
7	Онцгой байдлын газар
8	Орон нутгийн музей
9	Номын сан
10	Хөгжимт драмын театр
11	Ховд аймаг дахь төрийн Аудитын газар
12	Санхүү, төрийн сангийн хэлтэс
13	Төрийн албаны салбар зөвлөл
14	Монгол банк
15	Татварын хэлтэс
16	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
17	Хүнс, хөдөө аж ахуйн газар
18	Мал эмнэлэгийн газар
19	Зооноз өвчин судлалын төв
20	Ус, цаг уур орчны шинжилгээний төв
21	Цагдаагийн газар
22	Гаалийн газар
23	Хөдөлмөр эрхлэлтийн алба
24	Ховд аймгийн Авто тээврийн төв
25	Гадаадын иргэний харьяатын Баруун бүсийн газар

-оОо-